

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

"2/Засгийн газрын гишүүнийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39² дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тус тус заасны дагуу Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулсны үндсэн дээр томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулахдаа захирамж гаргана;"

2/ 30 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:

"10.Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах аргачлалыг Засгийн газар батална."

3/ 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Засгийн газар нь албан ёсны бэлгэдэлтэй байх бөгөөд Засгийн газар гэсэн нэршил, бэлгэдлийг иргэн, хуулийн этгээд хэрэглэхийг хориглоно."

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлд заасан ёсоор Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ." гэсний дараа "Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно." гэсэн 2 дахь өгүүлбэр, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх бөгөөд тангараг өргөх журмыг Улсын Их Хурал тогтооно." гэсэн 2 дахь өгүүлбэр, 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хэрэг эрхлэх газарт салбарын бодлогын хэрэгжилтийн уялдаа холбоог хангуулах, яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангахад зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын шийдвэр боловсруулах үүрэг бүхий Засгийн газрын ахлах референт, Засгийн газрын референт ажиллана." гэсэн 2 дахь өгүүлбэр, 36 дугаар зүйлийн гарчгийн "тэмдэг" гэсний дараа ", бэлгэдэл" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дараахь зүйл, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 4 дүгээр зүйл:

"4 дүгээр зүйл. Засгийн газрыг эмхлэн байгуулах үндэслэл, журам

1.Засгийн газрыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, гучин есдүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зургадугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу эмхлэн байгуулна.

2.Ерөнхий сайдыг огцруулах, шинээр томилох, чөлөөлөх болон Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай асуудлыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, дөчин гуравдугаар зүйл, дөчин дөрөвдүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зургадугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу Улсын Их Хурал шийдвэрлэнэ."

2/ 21 дүгээр зүйл:

21 дүгээр зүйл. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацаа

1.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь Үндсэн хуулийн дөчдүгээр зүйлд заасан Засгийн газрын бүрэн эрхийн хугацаатай адил байх бөгөөд Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно.

2.Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах тухай тогтоолыг баталсан тохиолдолд Ерөнхий сайд огцорно.

3.Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.

4.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас огцорсон, чөлөөлөгдсөн, түүнчлэн нас нөхчсөн тохиолдолд түүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно. Ерөнхий сайд огцорсон, чөлөөлөгдсөн, нас нөхчсөн тохиолдолд Улсын Их Хурал 30 хоногийн дотор түүнийг нөхөн томилно.

5.Засгийн газрын гишүүний орон гарсан тохиолдолд Ерөнхий сайд түүнийг энэ хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан журмын дагуу 14 хоногийн дотор нөхөн томилно. Нөхөн томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь тухайн Засгийн газрын бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

6.Ерөнхий сайдын бүрэн эрх биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсны улмаас чөлөөлөгдсөн, нас нөхчсөн үндэслэлээр хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд Ерөнхий сайдыг шинээр томилох хүртэл түүний үүргийг Шадар сайд гүйцэтгэнэ.

7.Засгийн газрын орон гарсан гишүүнийг нөхөн томилох хүртэл Ерөнхий сайд Засгийн газрын нэг буюу хэд хэдэн гишүүнд түүний үүргийг хуваарилан хариуцуулж болно.

8.Засгийн газар бүрэлдэхүүнээр огцорсон нь уул бүрэлдэхүүнээс албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж ирсэн хүнийг Засгийн газрын гишүүнээр дахин томилоход саад болохгүй.”

3/ 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

“1/Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхийлөгчтэй 1 хоногийн дотор зөвшилцөж чадаагүй тохиолдолд Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ;”

4/ 26 дугаар зүйлийн 1-4 дэх хэсэг:

“1.Засгийн газар нь Улсын Их Хурлын итгэлийг хүлээсэн байвал зохино.

2.Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Улсын Их Хурал тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38¹ дүгээр зүйлд заасан журмын дагуу хэлэлцэж Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайд огцорно.

3.Энэ хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Засгийн газрын гишүүдийн дөрөвний гурваас доошгүйн ирцтэй хуралдаанаар хэлэлцсэн байвал зохино.

4.Улсын Их Хурал өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолыг баталсан бол энэ тухай шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор Ерөнхий сайд уг асуудлыг дахин санаачлах эрхгүй.”

4 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “25.9-25.11-д” гэснийг “27.10-т” гэж, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хариуцна. Түүний дотор” гэснийг “хариуцаж, дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж, мөн хэсгийн 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь заалтыг дугаарыг “3, 4, 5, 6, 7, 8, 9” гэж тус тус, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “Ерөнхий сайд, улмаар Улсын Их Хурлын” гэснийг “Ерөнхий сайдын” гэж, 26 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн “Засгийн газрын гишүүн” гэснийг “Ерөнхий сайд” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 9 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2, 33.1.5 дахь заалтын “Засгийн газрын гишүүн,” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 38¹ дүгээр, 39² дугаар зүйл тус тус нэмсүгэй:

1/ 38¹ дүгээр зүйл:

“38¹ дүгээр зүйл. Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх асуудлыг хэлэлцэх журам

38¹.1. Ерөнхий сайд Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Төрийн байгуулалтын байнгын хороо уг тогтоолын төслийг өргөн мэдүүлснээс хойш 3 хоногийн дараа хуралдаж, санал, дүгнэлт гаргана.

38¹.2. Байнгын хорооны санал, дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор нэгдсэн хуралдааныг зохион байгуулж Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож илээр санал хураалт явуулж нийт гишүүний олонхи дэмжсэн бол Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцно. Улсын Их Хурлын тогтоолыг баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж, тухай асуудлыг дэмжсэнд тооцно.

38¹.3. Улсын Их Хурлын тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцруулах тухай тогтоол батлагдсанд тооцно.”

2/ 39² дугаар зүйл:

“39² дугаар зүйл. Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах журам

39².1. Ерөнхий сайд томилогдоноосоо хойш 5 хоногийн дотор Засгийн газрын гишүүнд нэр дэвшигчийг Ерөнхий сайд Төрийн байгуулалтын байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд танилцуулна.

39².2. Засгийн газрын гишүүнд нэр дэвшигчийг Ерөнхий сайд Төрийн байгуулалтын байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Ерөнхий сайдаас асуулт асууж, уг хэлж болно.

39².3. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Ерөнхий сайдаас асуулт асууж, уг хэлж болно.

39².4.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр нэр дэвшигчийн талаар санал хураалт явуулахгүй.

39².5.Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулахын өмнө Улсын Их Хуралд энэ зүйлд заасан журмын дагуу танилцуулна.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дараах зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“37 дугаар зүйл. Ерөнхий сайдыг томилох асуудлыг хэлэлцэх журам

37.1.Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг томилуулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш Төрийн байгуулалтын байнгын хороо 3 хоногийн дотор хуралдаж санал, дүгнэлт гаргана.

37.2.Нэгдсэн хуралдаан Ерөнхийлөгчийн танилцуулга, Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож илээр санал хураалт явуулж нэр дэвшигчийг нийт гишүүний олонхи дэмжсэн бол түүнийг Ерөнхий сайдаар томилох тухай тогтоол батлагдсанд тооцно.

37.3.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Ерөнхийлөгчийн танилцуулга, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулалт, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, уг хэлж болно.

37.4.Нэр дэвшигчийг нийт гишүүний дэмжээгүй бол Ерөнхийлөгч 5 хоногийн дотор Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу нэр дэвшигчээс өөр хүнийг Улсын Их Хуралд оруулна.

38 дугаар зүйл. Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг хэлэлцэх журам

38.1. Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Төрийн байгуулалтын байнгын хороо уг саналыг өргөн мэдүүлснээс хойш 3 хоногийн дараа хуралдаж, санал, дүгнэлт гаргана.

38.2.Байнгын хорооны санал, дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор нэгдсэн хуралдааныг зохион байгуулж, Байнгын хорооны санал, дүгнэлтийг, хэрэв Цэц дүгнэлт гаргасан бол түүний дүгнэлтийг сонсож илээр санал хураалт явуулж нийт гишүүний олонхи дэмжсэн бол огцруулах тухай тогтоол батлагдсанд тооцно.

38.3. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд асуулт асууж, уг хэлж болно.

38.4.Ерөнхий сайдыг огцруулах асуудлаар нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

38.5.Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нэгдсэн хуралдаан дээр уг хэлж болно.

38.6.Улсын Их Хуралд олонхийн суудал авч Засгийн газар байгуулсан эвсэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27.10-т заасны дагуу

тарсантай холбогдуулж Ерөнхий сайд огцрох хүсэлтээ Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол энэ зүйлд заасан журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

39¹ дүгээр зүйл. Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг хэлэлцэх журам

39¹.1. Ерөнхий сайд эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан бол Төрийн байгуулалтын байнгын хороо уг хүсэлтийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дараа хуралдаж, санал, дүгнэлт гаргана.

39¹.2. Энэ хуулийн 39¹.1-д заасан хүсэлтийг Байнгын хорооны санал, дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн илээр санал хураалт явуулах бөгөөд чөлөөлөгдөх хүсэлтийг нь хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхи дэмжсэн бол Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай тогтоол батлагдсанд тооцно.

39¹.3. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх шалтгаан үндэслэлийн талаар гишүүд асуулт асууж, уг хэлж болно."

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах талаар Ерөнхий сайдаас ирүүлсэн саналтай танилцана." гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2. Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцэн олонхийг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг; бусад тохиолдолд Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцэн олонхийг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна."

3 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 15 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хууль тогтомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.9 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“12.2.9. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох, чөлөөлөх;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар бүлэгт дор дурьдсан агуулгатай зүйл нэмсүгэй:

"15.31 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль зөрчих

1. Монгол Улсын Засгийн газрын албан ёсны нэр, бэлгэдлийг хэрэглэсэн бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Монгол Улсын Засгийн газрын албан ёсны нэр, бэлгэдлийг хэрэглэж худал мэдээлэл тараасан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь хэсгийн “15.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг,” гэсний дараа “15.31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 18 дугаар тогтоолын хавсралтын “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” хэсгийн “Эрхэлсэн түшмэл” гэсэн ангиллын “АА-4” зэрэглэлийн “Албаны дарга, ахлах зөвлөх” гэснийг “Албаны дарга, Засгийн газрын ахлах референт” гэж, “АА-5” зэрэглэлийн “Зөвлөх, ахлах референт” гэснийг “Засгийн газрын референт” гэж, “Ахлах түшмэл” гэсэн ангиллын “АА-6” зэрэглэлийн “Референт” гэснийг “Ахлах шинжээч” гэж, “АА-7” зэрэглэлийн “Ахлах шинжээч” гэснийг “Шинжээч” гэж тус тус өөрчилсүгэй.

2.Мөн хавсралтын “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” хэсгийн “Ахлах түшмэл” ангиллын “АА-8” зэрэглэлийн “Шинжээч” гэснийг хассугай.

3.Энэ тогтоолыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ